

ӨВӨР МОНГОЛ ДАХЬ ДАЙРАЛЦААНЫ АМАН ЗОХИОЛЫН АМЬД УЛАМЖЛАЛ¹

Өрлөгхүү

Abstract: *Dairaltsaa*, one of the traditional genres of Mongolian oral literature, has been showing many kinds of variations in both contents and forms, with the gradual change of life style and cultural contexts. Taking the living tradition of *Dairaltsaa* in Inner Mongolia Autonomous Region of China as a case, the contents include various elements such as cattle herding, hunting, farming, and influences of different religions, as well as those of Chinese written literature; in forms, it shows the feature of inter-textuality or integration of many other oral genres. In the way of performance and transmission, it is more and more adopted to the internet context, and is often performed on-stage now. It has been inscribed on the list of Intangible Cultural Heritages of Inner Mongolia, and some *Dairaltsaa* were selected in the reading materials of elementary schools.

Түлхүүр үг: Дайралцаа, монгол аман зохиол, интернэт

Товч агуулга: Монгол ардын уламжлалт аман зохиолын нэгэн зүйл болох дайралцаа нь нийгэм, цаг үе, соёл иргэншлийн хувирал өөрчлөлтийг дагалдан агуулга нь явах тусам өргөжин тэлж, хэлбэр нь нийлэлдэн баяжиж, уламжлан дамжуулах арга зам нь ч шинэтэн олширч байна. Өвөр монголд хэлэгддэг дайралцаагаар жишээлэхэд, агуулгад нь малжих, агнах, тариалах зэрэг олон зүйлийн амьдрал оршлын элемент ба шашин суртахууны нөлөө, хятад үндэстний бичгийн соёлын нөлөө тодорхой тусгагдах бөгөөд битүү холбоо, цэц булаалдлага, цэц булаалдах үгийн хэлбэрийг ч шингээж, ардын аман яруу найраг ба тайзны тоглолтын шинжийг зэргэд илрүүлдэг. Өвөр монголд дайралцаа нь бас сургуулийн хүүхдийн “Унших бичиг”-т орж, ӨМӨЗО-ы биет бус соёлын өв болж, хуулийн хамгаалалтыг хүлээсэн бөгөөд интернэтийн орчинд дасан зохицсоноор уламжлалаа залгаж чадсан байна.

Дайралцаа бол монгол ардын уламжлалт аман зохиолын нэгэн зүйл мөн. Аман зохиолын төрөл ангиллын хувьд, эрдэмтэд түүнийг адил бус үндэслэлээр адил бус аймаг төрөлд хамруулан өгүүлсэн байдаг. Жишээлбэл, БНХАУ-ын аман зохиол судлаач эрдэмтэн Мандах (2014:406-421) бээр монгол ардын аман зохиолыг аман яруу найраг, ардын үлгэр тууль, ардын жүжиг наадам хэмээх гурван аймагт ангилаад, дайралцааг аман яруу найргийн аймгийн холбоо шүлгийн төрөлд хамруулан өгүүлсэн бол, Монгол Улсын эрдэмтэн Ш.Гаадамба, Д.Цэрэнсодном², Х.Сампилдэндэв нарын судлаачид дайралцааг ардын жүжиг наадмын холбоо шүлгийн зүйлд хамруулсан байдаг.

¹ Энэхүү өгүүлэл нь БНХАУ-ын нийгмийн шинжлэх ухааны суурь мөнгийн “Анхаарагдаагүй буюу уламжлал тасарсан шинжилгээний салаа”-гийн судалгааны тусгай төсөл бөгөөд Төвийн Үндэстний Их Сургуулийн дундын үндэстний уламжлалт соёлын солилцооны судлалын хамтын төсөл - “Монгол үндэстний аман уламжлал хийгээд монгол, хятад соёлын уусалдал” (Зөвшөөрсөн дугаар: 20VJXT008)-ын шатаг чанартай үр бүтээл болно.

² Гаадамба Ш., Цэрэнсодном Д. 1984. Монгол ардын аман зохиолын дээж бичиг. Өвөр Монголын Ардын Хэвлэлийн Хороо., х.412-422. Ш.. Гаадамба, Х.Сампилдэндэв. 1988. “Монгол ардын аман зохиол”. (1988 он, Улаанбаатар)-д дайралцаа ба цэц булаалдах үгийг мөн жүжиг наадмын аман зохиолд багтаажээ.

Үүнээс гадна Өвөр монголын эрдэмтэн Буянхишиг, Төгсбаяр нар³ мөн дайралцааг жүжиг тоглоомын аман зохиолын ардын холбоогийн төрөлд багтаан өгүүлсэн бол, Ш·Буянтогтох, Ван Жин Хуа нар⁴ монгол хүүхдийн аман зохиолын бичвэрүүдийг эмхэтгэн хэвлүүлэхдээ дайралцааны бичвэрүүдийг тусгай зүйлээр сийрүүлсэн байдаг.

Харин энэ мэтийн нэгдэлгүй байдал бий болсны учрыг эрдэмтэд мөн нягталж байсны дотор Мандах “Битүү холбоо, дайралцаа холбоог ямагт өрсөлдөн мөрийцөх маягаар хэлдэг ба ардын заншилд үүнийг ‘холбоо булаалдана’ гэж хэлдэг. Холбоо булаалдах бол ухаан санаа оюун билгээ шалгах уран үг хавлаг хэллэгээ мөрийцөх ба шог инээдэм болгох зугаа наадмын шинжтэй нэг зүйлийн ардын урлагийн хэлбэр юм. Түүнийг хэлэхэд хоёр этгээд гар эргүүлэн эргэлдэж, газар дэвсэн сүлжилдэж байдгаараа зохих хэмжээгээр тоглолтын чанартай. Яг ч дээрх байдлыг нь үндэслэж, зарим эрдэмтэд түүнийг аман зохиолын жүжиг наадмын төрөл аймагт багтаан өгүүлдэг” (Мандах, 2014:417) хэмээсэн нь зүйтэй юм. Дайралцаа нь яг үнэхээр аман яруу найраг ба ардын жүжиг наадмыг сундалсан хам шинжтэй бөгөөд нийгэм, цаг үе, соёл иргэншлийн тасралгүй хувиран өөрчлөгдөхийг дагаж, агуулга нь явах тусам өргөжин тэлж, хэлбэр нь явах тусам нийлэлдэн баяжиж, уламжлан дамжуулах арга зам нь ч шинэтэн олширч байгаа ажээ. Үүнийг БНХАУ-ын Өвөр монгол орны дайралцааны амьд уламжлалын жишээн дээр тулгуурлан задалбаас нэн ч тодорхой харагдана.

Нэг. Агуулгын олон эшт шинж

Дайралцаа нь БНХАУ-ын Өвөр монголын зүүн бүс нутагт харьяалагдах Улаанхад, Тунляо, Хянган зэрэг аймаг хотын монголчуудын дунд амьд уламжлалаа хадгалсаар байна. Өвөр монголын зүүн бүс нутаг нь газар зүйн хувьд уул, тал, элс зэрэг олон янзын хөрс шороо алагласан бөгөөд эртнээс аваад олон зүйлийн үндэстэн ястан оршин амьдарч ирсэн болохоор соёл иргэншил нь бусад бүс нутгаас будилаантай байдаг. Тэр онцлог нь дайралцааны үг бадагт тодорхой илэрч байна.

Эн тэргүүнд, монголчуудын уламжлалт аман зохиол болсон дайралцаанд монгол хүмүүний аж амьдрал, оршихуйн үндэс болсон малжих аж ахуйн элемент маш олон байна. Жишээлбэл:

“Жэ хөөе үнэхээр тийм үү дээ?

Арван тавны сарыг

Ар дээр гартал хэлэлцье

Адуу болон малыг

Бэлчээрт гартал хэлэлцье

Хорин тавны сарыг

Хойт дээр гартал хэлэлцье

Хонь болон ямааг

Бэлчээрт гартал хэлэлцье” (Буянтогтох Ш., Жинь хуа Ван. 2006:465)

гэх бадагт “үүр цайтал, өглөө болтол” гэдгийг “Адуу үхэр бэлчээрт гартал” хэмээн малчин хүмүүний цагийн ойлголттой холбон илэрхийлж байна. Энэ тухай жишээ маш олон болохоор илүү нуршихыг больё.

Дараалбал, дайралцаанд агнах аж амьдралын ул мөр ч тусгагддаг. Жишээлбэл:

“Баруун ч хан уулан дээр

Бар алагсан миний аав

³ Буянхишиг, Төгсбаяр. 1990. Монгол ардын аман зохиолын шинжлэл. Өвөр Монголын Их Сургуулийн Хэвлэлийн Хороо., х.352-365.

⁴ Буянтогтох Ш., Жинь Хуа Ван. 2006. Монгол хүүхдийн аман зохиолын чуулган (дээд), Өвөр Монголын Сурган Хүмүүжлийн Хэвлэлийн Хороо., х.440-517.

*Бамбуу хорхойд туугдаад
Уйлж байсан чиний аав
Зүүн ч хан уулан дээр
Зүр алагсан миний аав
Зөгий хорхойд хазагдаад
Уйлж байсан чиний аав”⁵*

Монголчууд эртнээс малчин бөгөөд анчин явсан ард түмэн. Ялангуяа Өвөр монголын зүүн бүс нутгийн Хянган даваа дагасан газар орны хэсэг монголчууд нь эвэнк, дагуур, орчон зэрэг агнах амьдралаар голлосон үндэстэн ястнуудтай адилаар агнахыг малжихаас чухал байранд тавьж ирсэн түүхтэй. Хятад ардын зүйр цэцэн үгэнд “Уул түшсэн нь уулаа иднэ, гол түшсэн нь голоо иднэ” хэмээн хэлдгийн учир энэ юм. Ойрын хэдэн арван жилээс өвөр монголд ан гөрөө ховордсон, тоор хүрээ арвидсан, агнаж авлахыг хориглосон зэрэг шалтгаанаас агнах ажиллагаа цөөрсөн ч соёл уламжлалд нь ан агнуурын аж амьдралын ул мөр тодорхой байсаар гэдгийг өмнөх жишээнээс мэдэж болно.

Гутгаарт, дайралцаад тариалах аж амьдралыг тусгасан үг хэллэг, дүрслэл ч олон тохиолдоно. Жишээлбэл:

*“Баръя гэсэн тарианыхаа
Дундаас нь гараад ирлээ би
Банжин⁶ таван лан архиар
Умдаа дараад ирлээ би...
...Хадаж байсан тарианыхаа
Хагасыг нь хаяад ирлээ би
Хоёр гурван жин архиар
Хоолойгоо норгоод ирлээ би”* (Буянтогтох Ш., Жинь хуа Ван. 2006:441-442)

гэх бадагт дайралцах гэж яаран ирлээ гэсэн санаагаа “Хадаж байсан тариагаа хаяад гарч ирсэн” хэмээн тариачин хүмүүний ажил амьдралтай холбон илэрхийлж байна. Өвөр монголын зүүн бүс нутгийн Шар мөрөн, Ляохэ голын сав дагуу орон нь хөрс шороо сайтай, үр тариа ургаж боловсроход тохиромжтой болохоор энэ нутгийн хүмүүс тариалах аж ахуйг их эртнээс эрхэлж иржээ. Түүнд зөвхөн хятад үндэстний ард түмэн төдий биш, монгол, кидан зэрэг нүүдэл малжилд суурилсан үндэстэн ястны ард түмэн ч багтаж байсан юм. Ялангуяа ойрын хоёр гурван зуун жилээс эндэх орны аж ахуй нь ерөнхийдөө цөм малжих тариалах хосолсон шинжтэй болжээ.

Дөтгөөрт, дайралцаанд шашны үг хэллэг ба ойлголт ч элбэг тохиолдож байна. Жишээлбэл:

*“Этгээд зөрүү бүү яв хө
Илжиг болоод төрчихнө шүү
Эргэн дээрээ эртийж байтал
Эмсүүд бариад хүлчихнэ шүү
Хулжин хуйхар буу яв хө
Хулгана болоод төрчихнө шүү
Хоргоны цаагуур хорчгонож байтал*

⁵ Зохиогч миний нутаг болох өвөр монголын Улаанхад хотын Ар хорчин хошуунд өргөн тархсан дайралцааны үг.

⁶ Банжин-хагас жин гэсэн утгатай хятад зээллэг үг.

*Хуузтай муур нь барьчихна шүү*⁷

гэх буюу

“Эргэн дээрээ гарахад чинь

Элээ чамайг дуудаж байна

Эргэнээсээ буухад чинь

Эрлэг чамайг дуудаж байна

Хадан дээрээ гарахад чинь

Харцгай чамайг дуудаж байна

Хаднаасаа буухад чинь

Халуун тамд дуудаж байна”⁸

гэх мэтээр шүлэглэхэд “Эрлэг”, “Там” гэх мэт бурхны шашны үгс илэрч байгаа бөгөөд “Элээ, харцгай” гэх зэргийн бөөгийн хөлгө болох жигүүртний нэр ч түүнтэй зэрэгцэн дурдагдаж байгаа нь энэхүү дайралцааг бий болгосон соёлын хөрсөнд бурхны шашны нөлөө, бөө мөргөлийн ойлголт аль аль нь нэвчин байгааг тодорхой харуулж байна.

Тавдугаарт, дайралцаанд хятад түүх шастираас эхтэй үг хэллэг, шүлэг ч холилдон орсон байдаг. Энэ нь голдуу хятад түүх шастирын агуулга нь бэнсний үлгэр буюу хуурын үлгэрийн хэлбэрээр Өвөр монголын зүүн бүс нутагт өргөн тархсантай холбоотой юм. Жишээлбэл:

“Жэ хөөе үнэхээр тийм үү?

Тан тангийн чулуун дээр

Тамга дарж хэлэлцье

Тан улсаас аваад

Түүх татаж хэлэлцье.

Гол голын дэнжин дээр

Горим тавьж хэлэлцье

Гурван улсаас аваад

Түүх татаж хэлэлцье” (Буянтогтох Ш., Жинь Хуа Ван. 2006:462)

гэх шүлэгт “Тан улс” “Гурван улс” хэмээх хятадын түүх шастирт олон гардаг эртний улс гүрний тухай мэдлэгээр хэмжүүр болгон мэтгэлцэж байна.

Энэхүү таван зүйл зурваст жишээгээр үзэхэд Өвөр монгол дахь дайралцааны үг, шүлэгт олон зүйлийн эш сурвалж, ирэл гарал бүхий соёлын элементүүд зэрэгцэн нийлэлдэж байдгаараа агуулгын талаар олон эшт шинж онцлогтой болсон байна.

Хоёр. Хэлбэрийн хам шинж

Дайралцаа бол аман яруу найргийн аймаг ба ардын жүжиг наадмын аймгийг сундалсан шинжтэй бөгөөд эрдэмтэд түүнийг адил бусаар төрөлжүүлэн ангилж байна гэмээ нь өмнө өгүүлсэн билээ. Учир нь ерөнхий хэлбэрийн хувьд түүний бие дээр үнэхээр ардын аман зохиол, наадам тоглоом, тэрчлэн жүжиглэх урлаг, тайзны урлаг гэх мэтийн олон зүйлд холбогдсон нийлмэл буюу хам шинж илэрдэг байна. Түүнийг дараах хэдэн жишээнээс тодорхой олж харж болно.

Эн тэргүүнд, дайралцаа нь битүү холбоотой хутгалдан хэлэгддэг үзэгдэл түгээмэл орших болжээ. Битүү холбоо гэдэг бол ардын дундах холбоо шүлгийн нэгэн зүйл мөн. Тэр нь мөн

⁷ Сэржгочоо Д. *Дайралцаа*. интернэт хаяг: <http://www.holvoo.net/article/articleView.do?id=6af71694-f618-492a-bd92-784c31c87315>

⁸ Дээрхийн адил.

хоёр хүмүүн буюу хоёр талцсан хүмүүс өлгөлцөн холбох хэлбэрээр хэлэлцдэг, оньсогын шинжтэй буюу мэдлэгийн шинжтэй зүйлсийг асуулцан хариулалцаж, үгийн цэц, мэдлэг мэдцээр мөрийцдөг. Одоогийн дайралцаанд иймэрхүү хэлбэрийн зүйлс хутгалдан хэлэгддэг үзэгдэл олширчээ. Жишээлбэл:

Нэг нь:

*“Жээ хөөе, үнэхээр тийм үү дээ
Галбарагчаа зандан мод
Газрын хаанаас ургав?
Гарди галбинга шувуу гэж
Ямар модонд өндөглөв?”* (Эрдэнэбат, Юй Боо. 2015:345)⁹

гэж асуухад нөгөө нь:

*“Жээ хөөе, үнэхээр тийм үү дээ
Галбарагчаа зандан мод
Газрын хөрснөөс ургав
Гарди галбинга шувуу гэж
Тэнгэрийн модонд өндөглөв”* (Эрдэнэбат, Юй Боо. 2015:345-346)

гэж хариулдаг. Үүнээс гадна бас өмнө өгүүлсэн мэт бэнсний үлгэр буюу хуурын үлгэр, эсвэл Гэсэрийн туулийн өгүүлэмжээс эхтэй мэдлэг мэдцийн зүйлс битүү холбоогийн хэлбэрээр дайралцаанд холилдон орсон үзэгдэл бий. Жишээлбэл:

*“Жээ хөөе, үнэхээр тийм үү?
Ямаатын уулын сэтэрхийг
Ямар мэргэн харвав?
Ян Жье, Хуу Жье хоёулаа
Ямар гол дээр эндэв?
Ян Сэн боо, Мү Гүй ин
Хэдэн төрлийн эр эм буй?
Ян Лиан гүн өвгөн
Юуг мөргөөд үхэв?”* (Эрдэнэбат, Юй Боо. 2015:349)

гэсний хариуд:

*“Жээ хөөе, үнэхээр тийм үү?
Ямаатын уулын сэтэрхийг
Гэсэр мэргэн харвав
Ян Жье, Хуу Жье хоёулаа
Лан хе (чино) гол дээр эндэжээ
Ян Сэн боо, Мү Гүй ин
Гурван төрлийн эр эм гэнэ
Ян Лиан гүн өвгөн
Пайлууг мөргөөд үхэв гэнэ”* (Эрдэнэбат, Юй Боо. 2015:349-350)

гэж хариулдаг байна. Энд гарч байгаа Ямаатын уулын сэтэрхий нь Гэсэр мэргэний харваснаас болсон гэдэг өгүүлэмж нь Өвөр монголын Ар Хорчин хошуу, Байрин хошуу зэрэг газар орны ардын дунд хэлэгддэг Гэсэр хааны тухай домог туулиас эхтэй байхад Ян Жье, Хуу Жье, Ян

⁹ Эрдэнэбат., Юй Боо. 2015. Ар хорчны монгол ардын аман зохиол жан үйлийн сонгомол. Өвөр Монголын Шинжлэх Ухаан Техник Мэргэжлийн Хэвлэлийн Хороо., х.345-346.

Сэн боо, Мү Гүй ин, Ян Лиан гүн өвгөн зэрэг нь цөм Өвөр монголын зүүн бүс нутгийн олон хуурчдын хэлдэг хятадын Сүн улсын үлгэрт гардаг хүний нэрс юм. Битүү холбоо нь үнэндээ дайралцаанаас ялгаатай. Тэр нь зөвхөн мэдлэг мэдцийн асуулт хариултаар мэтгэлцэхээс биш, харин “дайр-” гэх язгуур бүхий дайралцаа шиг хошигнон егөөдөх, хорсгон доромжлох, басаж гүтгэх, мууг нь малтах, харааж зүхэх зэргээр нэгнээ мохоох гэдэггүй. Харин энэ хоёр нийлэлдэн нэгдсэн нь цөм өлгөө холбоогийн хэлбэртэй бөгөөд шүлэг бүр нь “*Жээ хөөе, үнэхээр тийм үү дээ*” гэх үгээр эхэлдэг, мөн бас хоёулаа нөгөө этгээдээ хариуцах үггүй болтол гартаасны дараа тусгай үг шүлгээр “*худалддаг*” зэрэг нэлээд тодорхой бүтэц загвартай байдагтай ч холбоо бий бололтой. Иймээс мэдлэг мэдэц шалгалцах асуулт хариулт орсон дайралцааг зарим хүмүүс “*Битүү дайралцаа*” гэж, уламжлалт утга дахь дайралцааг “*Задгай дайралцаа*” гэлцдэг байна.

Дараалбал, дайралцаа нь цэц булаалдлага ба цэц булаалдах үгтэй хутгалдах буюу нийлэлцэх үзэгдэл ч байна. Хөхнуур мужид оршин суусан Дээд монголчуудад дайралцаа хэмээх нэрийдэл байдаггүй боловч дайралцаатай нэлээд төсөөтэй хэлбэрийн “*Цэц булаалдлага*” хэмээх аман зохиолын зүйл байдаг. Дээд монголчуудын цэц булаалдлага нь мөн дайрч даажигнах үг аястай боловч өвөр монгол дахь дайралцаа шиг тэр бүхнийг холбож шүлэглэж хэлэх шаардлагагүй, харин шүлэглэг хэлбэр ба үргэлжилсэн үгийн хэлбэрийг хослуульж хэрэглэдэг байна. Жишээлбэл:

- “- *Нөхөр өө, чи ман хоёр цэц булаалдаад үзвэл ямар байна ?*
- *Ай, чи намайг хүчирнэ гэж байхгүй шүү.*
- *Чамайг хүчрэхгүй юу байдаг юм?”*

гэх мэтийн энгийн ярилцаа байдаг бөгөөд, цаашилбал:

- “- *Авай хүүхээ*
- Чи хэзээ тийм сонин юм байлаа чи?*
- Явын нүхээр нар үзээд чи*
- Ямаан туруу (туурай)-гаар ус уугаад чи*
- Эргэний нүхээр нар үзээд чи*
- Илжгэн туруугаар ус ууж байлаа чи”* (Сэчинбат нар, 2013:5-9)¹⁰

гэх мэтийн шүлэг холбоо ч олон байдаг. Нарийвчлан үзвээс Дээд монголчуудын цэц булаалдлага нь үндсэндээ зөвхөн үргэлжилсэн үгийн хэлбэр ордгоороо Өвөр монгол дахь дайралцаагаас ялгагдаж байна.

Харин Өвөр монголчуудын “Цэц булаалдах үг” гэдэг нь өөр нэгэн зүйлийн аман зохиолыг хэлдэг байна. Жишээлбэл, Өвөр монголын Хөлөнбуйр аймагт хэлэгддэг “Өнчин хүү” хэмээх цэц булаалдах үгэнд:

- “- *Өнчин хүү! Юунд бөгсөө тонгойно чи?*
- *Халууцахдаа тонгойж байна.*
- *Халууцвал усанд умба.*
- *Урсахаасаа айна.*
- *Айвал бутыг барь*
- *Гар минь хатгагдана.*
- *Бээлий хий.*
- *Бээлий минь норно.*
- *Норвол хатаа.*
- *Хатаахад хорчийно.*

¹⁰ Сэчинбат, Эринзэн, Хөхөө, Буяннэмэх. 2013. Аман зохиолын хувилбарын харьцуулсан эмхэтгэл-Дээд монголын үлгэр туульс. Үндэстний Хэвлэлийн Хороо., х.5-9.

- *Хорчийвол нухал.*
- *Нухлахад эвдэрнэ.*
- *Эвдэрвэл оё.*
- *Оёх зүү утасгүй.*
- *Маймайгийн хятадаас ав.*
- *Зоос мөнгөгүй.*
- *Би өгөхүй даа”* (Буянтогтох Ш., Жинь Хуа Ван. 2006: 373-374)

Тэгээд өнчин хүү “Авахаар очно” гээд явна.

Цэц булаалдах үг нь энэ жишээнд үзүүлсэн мэтээр ямар нэгэн учир явдал, хэрэг үзэгдлийг ухчилж мөрдөж асуух хэлбэрээр өрнөдөг бөгөөд ерөнхийдөө шүлэглэсэн бус ярилцааны хэлбэртэй болохоор дайралцаанаас нэлээд ялгаатай. Гэвч дайралцаа нь зарим үед иймэрхүү агуулга, хэлбэрийг шингээгээд авчихдаг байна.

Мөн дайралцаж мэтгэлцэх арга хэлбэр, байр талбар нь янз бүр байдаг. Өвөр монголоор жишээлбэл, дайралцааг хоёр хүмүүн хоёр талцах буюу олон хүмүүн хоёр талцан дайралцаж болдог бөгөөд зарим байдалд олон хүмүүн олон талцаж дайралцах тохиолдол ч гардаг. Тэгэхдээ голдуу өсвөр насны хүүхэд багачуудын хэл сэтгэхүйг нь хурцлаг болгон боловсруулах үйлдэлтэй болохоор хүүхэд багачуудын дунд голдуу хэлэгддэг, томчуул ч хааяадаа наадам тоглоом хийх үүднээс дайралцан шоололцож ажлын чилээгээ тайлж, амьдралдаа хөөр хөг нэмэрлэдэг билээ. Тэр нь байр талбарын хувьд хээр гадаа малын зах, хадлангийн талбай, тарианы хажуу зэрэг ажил хөдөлмөрийн талбайд хэлэгдэж болдог бөгөөд айлын гэр, найрын танхим, тоглолтын тайзан дээр ч хэлэгдэж тоглогдож болдог. Хэлэх арга барилын хувьд аятай, аягүй янз бүр хэлэгдэж болдог бөгөөд заримдаа дөрвөн утаст хуур, цоор зэрэг хуур хөгжмөөр хавсран тоглодог.

Түүнчлэн дайралцан тоглох үедээ нүүр царайгаа бодож зурах, хиймэл сахал зүүх, жүжиглэхэд тусгай зориулсан хувцас өмсөх буюу янз бүрийн шог инээдэмтэй, амьд дүрслэг биеийн хөдөлгөөн хавсарган, жүжгийн шинжийг нь чангаруулдаг байна. Ялангуяа сүүлийн үед дайралцааг дуу болгож дуулах үзэгдэл моод болж байгаа нь ажиглагдаж бий. Үүнийг дараагийн агуулгад жишээтэй авч үзнэ.

Гурав. Уламжлал ба дамжууллын одоохич шинж

XX зууны сүүл, XI зууны эхнээс нааш даяаршлын урсгал урьд гараагүй ширүүсэж, хүмүүн төрөлхтний уламжлалт соёлд хатуу шалгалт тулгарсан байна. Энэхүү урсгал дайралцааг тойрч гараагүй нь мэдээж. Цаг үе хувирч, шинжилгээ мэргэжил хөгжин, хүмүүсийн амьдралын арга хэлбэр, айзам хэм өөрчлөгдсөнөөс амьд бодитой талбайд ам чигээр уламжлан сургах ба дамжуулан түгээж байсан байдал алдагдахад дөхөж, дайралцааны уламжлал тасрах түгшүүр нүүрлэж ирсэн байна. Гэвч урлаг соёлын үнэ цэн их, амьдралаас гүн үндэстэй, уламжлал шинэчлэлийн арга хэлбэр нь амьдлаг чөлөөтэй байдагтаа түшиж, дайралцаа нь дэмий удалгүй цаг үе, нийгэм, соёлын шинэ байдалд дасан зохицоод уламжлалаа залгаж чадсан юм. Үүнийг мөн Өвөр монгол нутаг дахь байдалд үндэслэж, хэдэн зурвас өгүүлье.

Нэгдүгээрт, дайралцаа нь БНХАУ дахь монголоор хичээллэх хүүхдийн хэл бичгийн хичээлийн “Унших бичиг”-г орсон байна. Өнгөрсөн зууны ная, ерээд оноос нааш монгол хэл бичгийн хичээлийн сурах бичгийн нөхвөр материал болох “Унших бичиг”-г цөм дайралцааны агуулга байжээ. Тодруулбал, өнгөрсөн зууны ная, ерээд оны үеийн тав буюу зургадугаар ангийн хүүхдийн “Унших бичиг”-г:

“Хэлэлцье гэвэл хэлэлцье дээ

Хэлтрэхээс чинь айна би

*Хэрмийн сүүдэр эрээд
Дутаахаас чинь айна би
Булаалцъя гэвэл булаалцъя даа
Балбарахаас чинь айна би
Бараан сүүдэр эрээд
Дутаахаас чинь айна би”*

гэх мэтийн үгтэй “Дайралцаа” хэмээх зохиол байсан билээ. Одоохон болтол хэрэглэгдэж байсан бага сургуулийн гуравдугаар ангийн хүүхдийн “Унших бичиг”-т:

*“А: За хөөе, үнэхээр тийм үү дээ
Мод шугуйн эмч гэж
Түүнийг юугаар тайлна вэ?
Муурын нүдтэй баатар гэж
Ямар шувууг хэлдэг бэ?
Э: За хөөе, үнэхээр тийм үү дээ
Мод шугуйн эмч гэж
Тоншуул шувуугаар тайлъя
Муурын нүдтэй баатар гэж
Ууль шувууг хэлдэг шүү” (Унших бичиг. 2016:62-70)¹¹*

гэх мэтийн үгтэй битүү холбоо буюу байгаль ахуйгаа хамгаалах мэдлэг мэдцийн тухай асууж хариулсан сэдэвт дайралцаа “*Хоёр жаалын дайралцаа*” хэмээх нэрээр байсан юм. Дайралцааг сургуулийн хүүхдэд уншуулах, зааж цээжлүүлэх агуулга болгож байсан нь түүний уламжлал залгамжлалд асар их идэвх үйлдэл гаргасан байна.

Дараалбал, дайралцаа нь ӨМӨЗО-ы дэсийн биет бус соёлын өвөөр тогтоогдож, хуулиар хамгаалагдсан байна. Шинэ зуунаас нааш ЮНЕСКО-аас хүмүүн төрөлхтний биет бус соёлын өвийг хамгаалах хөдөлгөөнийг дэлхий нийтийн хэвчээнд эрчтэй өрнүүлснээр дайралцааг багтаасан монгол аман зохиол зан үйлийн өв уламжлал ч аврагдан хамгаалагджээ. Тодруулбал, дайралцаа нь “хөөр наргианы хоорондуур хүмүүнд оюун ухааны сэнхрэл ба мэдлэгийн хүртээл олгохын зэргээр хурц цэцэн сэтгэхүйн дасгал болдгоороо бодитой хэрэглээний ач холбогдлоор өндөр, чухал их түүх, урлаг болон зугаа цэнгэлийн үнэ өртөгтэй, монгол үндэстэн төвлөрөн суурьшсан газар оронд өргөн дэлгэр бөгөөд алс хэтийн нөлөөтэй” учир 2009 онд Өвөр Монголын Үндэстний Дуурилагийн Бүлгэмийн мэдүүлэн дэвшүүлэхээр дамжиж, ӨМӨЗО-ы хоёрдугаар бүлгийн биет бус соёлын өвийн нэрсийн жагсаалтад орсон байна. Биет бус соёлын өв нь БНХАУ-ын хэвчээнд маш тодорхой хууль тогтоолын хамгаалалтыг хүлээдэг бөгөөд засгийн газар буюу хамаатай байгууллага нэгжээс уламжлагч хүмүүнийг тогтоох, заан сургалт эрхлэх, уралдаан тэмцээн зохион байгуулах зэргээр тодорхой арга хэмжээ авч уламжлал залгамжлалыг баталдаг юм. Жишээлбэл, ойрын арван жилийн дотор өвөр монголын Улаанхад хотын Байрин Баруун хошуу, Шилийн гол аймгийн Зүүн Үзэмчин хошууны зарим газрынхан дайралцааны тэмцээн зохион байгуулж өнгөрсөн байна.

Нэн чухал нэгэн зүйл гэвэл, дайралцаа нь радио, телевиз, интернэт зэрэг шинэ хэвлэл мэдээллийн хэрэгсэл, техник технологиор дамжин түгэх болов. XX зууны сүүлийн хагаст БНХАУ-д радио, телевиз түгээмэлжсэнээс радио, телевизийн соёл урлагийн сэдэвт хөтөлбөрөөр дайралцаа хааяа дамжигддаг байжээ. XXI зуунд орсноос нааш хүмүүн төрөлхтний нийгэм мэдээллийн эрин зуунд шилжиж, утга зохиол урлагийн зохион бүтээлгийн арга хэлбэр, уламжилж дамжуулах зууч, хүмүүн ардын сонирхол хүртгээлийн нөхцөл шаардлагад үсрэнгүй

¹¹ БНХАУ-ын албан журмын сурган хүмүүжлийн монгол хэл бичгийн “Унших бичиг”. Гуравдугаар оны доорд дэвтэр, Өвөр Монголын Сурган хүмүүжлийн Хэвлэлийн Хороо. 2016 он

их хувиралт гарчээ. Дамжуулах арга хэлбэр ч хүмүүсийн санаа зүүдэнд оромгүйгээр шинэтэн хувирч, үзэг цаас орхигдох тийшээ хандаж, сонин сэтгүүл, ном хэвлэл зэрэг цаасан хэвлэл мэдээлэл төдийгүй радио, телевиз зэрэг түгээмэл хэрэглэгдээд хагас зуун ч болоогүй мэдээллийн хэрэгсэл хүртэл төдхөн зуур хуучран, шинэ мэдээллийн хэрэгсэлд зам тавьж өгчээ. Ийнхүү сүүлийн үед дайралцаа нь интернэт жигүүртэй болж, цаг ба орон зайд хязгаарлагдахгүй, эрх чөлөөт ертөнцөд нисэн оржээ.

Дайралцаа интернэт ертөнцтэй золгож чадсан нь түүний уламжлал ба шинэчлэл эвлэг уялдсанд байгаа юм. Уламжлалын хувиас хэлэхэд, дайралцаа ер нь амьдлаг цовоолог агуулга хэлбэртэй бөгөөд урлаг соёлын талаар хэзээ ч гундаж хуучрахааргүй үнэ цэнтэй. Шинэчлэлийг нь голдуу хоёр талаас ойлгож болно. Нэгэнтээ дайралцаа нь хүмүүсийн оршин байгаа амьдрал ахуйтай нягт харьцаатай байдаг болохоор тасралгүй шинээр зохиогдож л байдаг. Одоо уулын шиг хоёул буюу олуул цуглараад дайралцах үзэгдэл бараг харагдахгүй болсон ч сүлжээ сайт, *WeChat* дээр аван барин холболцон дайралцаж байгаа үзэгдэл зөндөө бий. Нөгөөтээгүүр дайралцаа нь тайзны урлаг, дуу хөгжим зэрэг бусад төрөл хэлбэрийн урлагтай нийлэлдэн хөгжиж, хүмүүст шинэ таашаал эдлүүлэх болсон байна. Жишээлбэл, Өвөр монголын “Анд” хамтлаг дайралцааг олон зүйлийн урлагийн арга барил хавсаргасан дуу болгон дуулаад сонсогчдын хүрээллийг ихэд олж, АНУ-д очиж тоглохдоо энэ дуугаа дуулсан байна. Мөн бас Монгол Улсын дуучин Ж.Эрдэнэдалайгийн дуулсан “Дайралцаа” хэмээх дуу нь Өвөр Монголын сонсогчдод ихэд таашаагдаж байна.

Дүгнэлт

Өмнө ярьсан бүхий л зүйлсийг хураангуйлж, дараах хэдэн талаар дүгнэж байна.

Нэгдүгээрт, дайралцаанд олон эшт соёлын онцлог шинж тодорхой илэрдэг. Өвөр монгол дахь дайралцаанд малжих, агнах, тариалах зэрэг олон зүйлийн амьдрал оршлын элемент ба шашин суртахууны нөлөө, хятад үндэстний бичгийн соёлын нөлөө шингэсэн нь үүнийг харуулна.

Хоёрдугаарт, дайралцаа нь аман зохиол, урлаг, соёлын бусад төрөл зүйлийн элементийг олон шингээжээ. Өвөр монголчуудын дайралцаанд битүү холбоо, цэц булаалдлага, цэц булаалдах үгийн элемент олон тохиолддог.

Гуравт, дайралцаа нь сүүлийн үед дуу хөгжим, тайзны урлаг болон хөгжиж байна. Өвөр монголын “Анд” хамтлаг ба Монгол улсын дуучин Ж. Эрдэнэдалай нар дайралцааг дуу болгон дуулаад, сонсогчдын таашаалыг олжээ.

Дөрөвт, дайралцааны уламжлал нь шинэ цаг үетэй золгож чадсан байна. Дайралцаа нь Өвөр монголын хүүхдийн “Унших бичиг”-т орж, ӨМӨЗО-ы дэсийн биет бус соёлын өв болсон бөгөөд интернэт орчинд шинээр бүтээгдэж, цахим сүлжээгээр түгэн дамжигдах болсноор уламжлалаа залгаж чадсан байна.

Номзүй

- БНХАУ-ын албан журмын сурган хүмүүжлийн монгол хэл бичгийн “Унших бичиг”. 2016. Гуравдугаар оны доорд дэвтэр, Өвөр Монголын Сурган хүмүүжлийн Хэвлэлийн Хороо.
- Буянхишиг, Төгсбаяр.** 1990. *Монгол ардын аман зохиолын шинжлэл*. Өвөр Монголын Их Сургуулийн Хэвлэлийн Хороо.
- Буянтогтох Ш., Жинь Хуа Ван.** 2006. *Монгол хүүхдийн аман зохиолын чуулган (Дээд)*. Өвөр Монголын Сурган Хүмүүжлийн Хэвлэлийн Хороо.
- Гаадамба Ш., Цэрэнсодном Д.** 1984. *Монгол ардын аман зохиолын дээж бичиг*. Өвөр Монголын Ардын Хэвлэлийн Хороо.
- Гаадамба Ш., Сампилдэндэв Х.** 1988. *Монгол ардын аман зохиол*. Улаанбаатар.
- Мандах.** 2014. *Мандахын зохиолын чуулган. 1-р боть*. Өвөр Монголын Соёлын Хэвлэлийн Хороо.
- Сэчинбат, Эринзэн, Хөхөө, Буяаннэмх.** 2013. *Аман зохиолын хувилбарын харьцуулсан эмхэтгэл-Дээд монголын үлгэр туульс*. Үндэстний Хэвлэлийн Хороо.
- Эрдэнэбат, Юй Боо.** 2015. *Ар хорчины монгол ардын аман зохиол, зан үйлийн сонгомол*. Өвөр Монголын Шинжлэх Ухаан Техник Мэргэжлийн Хэвлэлийн Хороо.

Цахим эх сурвалж

Сэржгочоо Д. *Дайралцаа*. <http://www.holvoo.net/article/articleView.do?id=6af71694-f618-492a-bd92-784c31c87315>